ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2024/97/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2024 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................ 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....................................................5-9

3. Аудитын илрүүлэлт .........................................................................................................14

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..............................................................15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.22 № 156

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ГАНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Газрын кадастрын нэгдсэн системд Баяндун сумын Засаг даргын Тамгын газар эзэмшигчээр бүртгэлтэй 1827м$^2$ нам, олон нийтийн байгууллагын зориулалттай 3 газар байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 89.1 хувиар дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021067

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **566,972,259.7** | **239,954,676.9** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | **19,632,000.0** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 132,000.0 |
| **335** | **Бусад авлага** | - | **19,500,000.0** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 19,500,000.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **566,972,259.7** | **220,322,676.9** |
| **351** | **Түүхий эд материал** | **49,572,343.7** | **4,443,287.9** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,965,405.0 | 3,626,000.0 |
| 35130 | Эм боох материал | 45,606,938.7 | 817,287.9 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,896,000.0 | 21,296,000.0 |
| **354** | **Хангамжийн материал** | **396,908,108.0** | **78,987,581.0** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,519,535.0 | 1,950,510.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 48,224,974.0 | 36,537,071.0 |
| 35450 | Барилгын засварын материал | 952,000.0 | 500,000.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 340,211,599.0 | 40,000,000.0 |
| 35600 | Мал амьтад | 115,595,808.0 | 115,595,808.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,999,943,093.7** | **3,162,054,273.7** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,999,943,093.7** | **3,162,054,273.7** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,905,286,968.6** | **2,798,529,523.7** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 724,416,992.4 | 979,740,792.4 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (188,774,975.2) | (227,587,723.8) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 160,753,910.0 | 180,753,908.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (44,975,584.9) | (59,588,569.9) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 304,041,438.0 | 402,826,147.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (157,457,239.6) | (167,847,518.1) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,839,011.5 | 43,939,011.5 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,212,987.4) | (32,417,529.3) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 652,882,557.0 | 1,060,805,028.0 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (262,805,177.5) | (358,896,677.9) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 855,382,950.0 | 1,211,118,886.0 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (154,803,925.7) | (234,316,230.2) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 94,656,125.1 | 363,524,750.0 |
| 39301 | Програм хангамж | 2,467,200.0 | 1,500,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,267,074.9) | (31,250.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 108,256,000.0 | 378,256,000.0 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (13,800,000.0) | (16,200,000.0) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,566,915,353.3** | **3,402,008,950.5** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,566,915,353.4** | **3,402,008,950.5** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,566,915,353.4** | **3,402,008,950.5** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 649,935,015.2 | 919,935,015.2 |
| 51101 | Өмч: - төрийн | 649,935,015.2 | 919,935,015.2 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,474,619,770.9** | **2,039,713,368.1** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,038,309,732.3 | 1,474,619,770.9 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 436,310,038.6 | 565,093,597.2 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 442,360,567.2 | 442,360,567.2 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,566,915,353.4** | **3,402,008,950.5** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,126,871,726.0** | **1,793,515,376.4** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **513,128,318.0** | **1,090,448,755.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 513,128,318.0 | 1,090,448,755.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 513,128,318.0 | 1,090,448,755.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.0 | 600,000.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 512,528,318.0 | 1,089,848,755.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **613,743,408.0** | **703,066,621.4** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,555,008.0 | 18,826,821.4 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 750,000.0 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,144,608.0 | 18,441,821.4 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,660,400.0 | 385,000.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 607,188,400.0 | 684,239,800.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 607,188,400.0 | 684,239,800.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **690,561,687.4** | **1,211,900,112.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **689,176,687.4** | **871,688,513.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **513,790,755.0** | **828,866,461.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **243,940,106.0** | **333,260,789.2** |
| 210101 | Үндсэн цалин | 204,625,897.2 | 230,015,205.1 |
| 210102 | Нэмэгдэл | 23,751,835.0 | 79,721,597.8 |
| 210104 | Урамшуулал | 15,562,373.8 | 22,753,293.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 770,692.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,068,272.5 | 40,468,657.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,521,739.7 | 27,596,791.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,562,105.0 | 3,013,205.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,391,624.6 | 3,235,595.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 506,703.6 | 700,663.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,086,099.7 | 5,922,402.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12,368,455.0** | **23,103,599.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,066,096.2 | 14,450,799.5 |
| 210302 | Түлш, халаалт | 8,302,358.8 | 8,652,800.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,892,368.1** | **49,909,871.4** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,938,450.0 | 3,703,840.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,126,900.0 | 28,149,741.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,797,838.1 | 1,873,500.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,011,180.0 | 16,182,790.0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 18,000.0 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **480,000.0** | **46,259,587.6** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 480,000.0 | 43,824,407.6 |
| 210502 | Хоол, хүнс | - | 1,081,180.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,354,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **408,400.0** | **2,433,710.0** |
| 210604 | Урсгал засвар | 408,400.0 | 2,433,710.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,088,000.0** | **9,614,000.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,088,000.0 | 9,614,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,943,842.0** | **8,614,693.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.0 | 5,814,520.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,740,000.0 | 1,080,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 203,842.0 | 1,720,173.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **176,601,311.4** | **315,201,553.1** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,471,010.0 | 48,643,286.2 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 161,130,301.4 | 266,558,266.9 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **175,385,932.4** | **42,822,051.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **590,937.0** | **16,737,312.0** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 16,737,312.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 590,937.0 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 174,794,995.4 | 26,084,739.5 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 174,794,995.4 | 26,084,739.5 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,385,000.0** | **340,211,599.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,385,000.0 | 340,211,599.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,385,000.0 | 340,211,599.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **436,310,038.6** | **581,615,264.3** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 16,521,667.2 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 16,521,667.2 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (16,521,667.2) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **436,310,038.6** | **565,093,597.2** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **614,343,408.0** | **703,666,621.4** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **600,000.0** | **600,000.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 600,000.0 | 600,000.0 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 600,000.0 | 600,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.0 | 600,000.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **613,743,408.0** | **703,066,621.4** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,555,008.0** | **18,826,821.4** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 750,000.0 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,144,608.0 | 18,441,821.4 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,660,400.0 | 385,000.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 607,188,400.0 | 684,239,800.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 607,188,400.0 | 684,239,800.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **546,884,316.0** | **558,719,262.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **546,884,316.0** | **558,719,262.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **371,498,383.6** | **515,897,210.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 243,940,106.0 | 333,260,789.2 |
| 210101 | Үндсэн цалин | 204,625,897.2 | 230,015,205.1 |
| 210102 | Нэмэгдэл | 23,751,835.0 | 79,721,597.8 |
| 210104 | Урамшуулал | 15,562,373.8 | 22,753,293.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 770,692.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,068,272.5** | **40,600,657.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,521,739.7 | 27,728,791.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,562,105.0 | 3,013,205.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,391,624.6 | 3,235,595.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 506,703.6 | 700,663.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,086,099.7 | 5,922,402.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **13,441,175.0** | **23,103,599.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,066,096.2 | 14,450,799.5 |
| 210302 | Түлш, халаалт | 9,375,078.8 | 8,652,800.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,743,408.1 | 36,375,111.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,868,280.0 | 3,274,040.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,846,410.0 | 28,148,681.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,797,838.1 | 1,873,500.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,230,880.0 | 3,078,890.0 |
| **2105** | **Нормативт зардал** | - | **1,354,000.0** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,354,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **14,989,300.0** | **5,491,210.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 491,800.0 |
| 210604 | Урсгал засвар | 14,989,300.0 | 4,999,410.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,088,000.0** | **9,614,000.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,088,000.0 | 9,614,000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,943,842.0** | **8,614,693.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.0 | 5,814,520.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,740,000.0 | 1,080,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 203,842.0 | 1,720,173.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,284,280.0** | **57,483,150.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,284,280.0 | 57,483,150.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **175,385,932.4** | **42,822,051.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 590,937.0 | 16,737,312.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 16,737,312.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 590,937.0 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **174,794,995.4** | **26,084,739.5** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 174,794,995.4 | 26,084,739.5 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **67,459,092.0** | **144,947,359.0** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **67,459,092.0** | **144,947,359.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **67,459,092.0** | **144,947,359.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 67,459,092.0 | 144,947,359.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 67,459,092.0 | 144,947,359.0 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(67,459,092.0)** | **(144,947,359.0)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 649,935,015.2 | 442,360,567.2 | 1,038,309,732.3 | 2,130,605,314.7 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **649,935,015.2** | **442,360,567.2** | **1,038,309,732.3** | **2,130,605,314.7** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 436,310,038.6 | 436,310,038.6 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **649,935,015.2** | **442,360,567.2** | **1,474,619,770.9** | **2,566,915,353.4** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **649,935,015.2** | **442,360,567.2** | **1,474,619,770.9** | **2,566,915,353.4** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **649,935,015.2** | **442,360,567.2** | **1,474,619,770.9** | **2,566,915,353.4** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 270,000,000.0 | - | - | 270,000,000.0 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 565,093,597.2 | 565,093,597.2 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **919,935,015.2** | **442,360,567.2** | **2,039,713,368.1** | **3,402,008,950.5** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **684,839,800.0** | **658,755,060.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **538,839,800.0** | **513,807,701.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **505,276,900.0** | **497,070,389.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **331,659,500.0** | **331,633,889.2** |
| 210101 | Үндсэн цалин | 229,951,500.0 | 230,015,205.1 |
| 210102 | Нэмэгдэл | 79,800,000.0 | 79,721,597.8 |
| 210104 | Урамшуулал | 21,128,000.0 | 21,126,393.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 780,000.0 | 770,692.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **41,664,300.0** | **40,600,657.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,603,600.0 | 27,728,791.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,015,500.0 | 3,013,205.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,336,900.0 | 3,235,595.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 706,700.0 | 700,663.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,001,600.0 | 5,922,402.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,200,000.0** | **18,687,659.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,200,000.0 | 10,034,859.5 |
| 210302 | Түлш, халаалт | 9,000,000.0 | 8,652,800.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,298,300.0** | **26,596,130.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,681,300.0 | 3,028,040.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,650,000.0 | 19,869,700.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,142,100.0 | 1,873,500.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,824,900.0 | 1,824,890.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,356,500.0** | **1,354,000.0** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,356,500.0 | 1,354,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,492,900.0** | **5,491,210.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 492,900.0 | 491,800.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.0 | 4,999,410.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,238,000.0** | **9,074,000.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,238,000.0 | 9,074,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,281,700.0** | **8,614,693.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 10,369,200.0 | 5,814,520.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,080,000.0 | 1,080,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,832,500.0 | 1,720,173.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **55,085,700.0** | **55,018,150.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,085,700.0 | 55,018,150.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,562,900.0** | **16,737,312.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **33,562,900.0** | **16,737,312.0** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,737,400.0 | 16,737,312.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,825,500.0 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **146,000,000.0** | **144,947,359.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 146,000,000.0 | 144,947,359.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 146,000,000.0 | 144,947,359.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **684,839,800.0** | **658,755,060.5** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **684,839,800.0** | **658,755,060.5** |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 684,239,800.0 | 658,155,060.5 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.0 | 600,000.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **18,826,821.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,826,821.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,826,821.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,626,900.0** |
| 210104 | Урамшуулал | 1,626,900.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,415,940.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,415,940.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,778,981.4** |
| 210401 | Бичиг хэрэг | 246,000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,278,981.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,254,000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **540,000.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 540,000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,465,000.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,465,000.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **18,826,821.4** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **18,826,821.4** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,441,821.4 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 385,000.0 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 294,908.5 мянган төгрөгийн 5 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*

- Худалдан авсан 770.0 мянган төгрөгийн GPS төхөөрөмжийг бүртгэл, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ, УСНББОУС -12-ын 4.17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Төсвөөс малын тэжээл худалдан авахад зарцуулсан тээврийн зардлын 3.1 сая төгрөгийг худалдан авалтын өртөгт нэмж бүртгээгүй нь УСНББОУС 12.9.33-т "Бараа материалын худалдан авалтын өртөг нь худалдан авсан үнэ, импорт татвар ба бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас тухайн аж ахуйн нэгж дараа нь нөхөн авч болохоос бусад), ***тээвэрлэлт***, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээний худалдан авалтад шууд хамаарах бусад

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үгнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зардлуудаас бүрддэг. ...", санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

- 2022 онд худалдан авсан 1.5 сая төгрөгийн санхүүгийн программыг бүртгэл, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэн, санхүүгийн тайлангийн санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй.
- Гэрээний дагуу КВОШ маркын авто машины засвар үйлчилгээ, сэлбэг худалдан авалтад зарцуулсан 19.5 сая төгрөгийг НББ-ийн стандартын дагуу давхар бичилтийг хийж урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Байгууллагын эзэмшлийн 270.0 сая төгрөгийн газрыг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 4,644.0 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 990.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ байгууллагын нэр дээр бүртгүүлэх, 1827м$^2$ эзэмшигчийг тодорхой болгож бүртгэл, хяналтыг сайжруулах 3,654.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон ажиллах 1 зөвлөмж өгч ажиллалаа.

### 3.1 Төлбөрийн акт

Засаг даргын 2023 оны А/108 дугаар захирамжаар спорт заалны төлбөрт зарцуулсан 990.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

- Хог тээвэрлэх зорилгоор 2022 онд худалдан авсан автотээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ байгууллагын нэр дээр эзэмшигчээр бүртгэлгүй байгаа нь санхүүгийн тайлангийн нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Газрын кадастрын нэгдсэн системд Баяндун сумын Засаг даргын Тамгын газар эзэмшигчээр бүртгэлтэй 1827м$^2$ нам олон нийтийн байгууллагын зориулалтай 3 газар байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, ангилал, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Тус газрын хөрөнгөд бүртгэлтэй 8 тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

улсын дугаар хэрэглэнэ", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авсан GPS төхөөрөмжийг бүртгэл, тайланд тусгаагүй | 1 | 770.0 | 1 | 770.0 | - | - | 1 | 770.0 | - | - | - | - |
| Малын тэжээл худалдан авахад зарцуулсан тээврийн зардал 3.1 сая төгрөгийг худалдан авалтын өртөгт нэмж бүртгээгүй | 1 | 3,138.5 | - | - | 1 | 3,138.5 | 1 | 3,138.5 | - | - | - | - |
| Санхүүгийн программыг бүртгэл, тайланд тусгаагүй | 1 | 1,500.0 | 1 | 1,500.0 | - | - | 1 | 1,500.0 | - | - | - | - |
| Авто машины засвар үйлчилгээ, сэлбэг худалдан авалтад 19.5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй, | 1 | 19,500.0 | - | - | 1 | 19,500.0 | 1 | 19,500.0 | - | - | - | - |
| Байгууллагын эзэмшлийн газрыг бүртгэл тайланд тусгаагүй | 1 | 270,000.0 | 1 | 270,000.0 | - | - | 1 | 270,000.0 | - | - | - | - |
| **Дүн** | **5** | **294,908.5** | **3** | **272.270.0** | **2** | **22,638.5** | **5** | **294,908.5** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

## Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтгүй гүйлгээ бүртгэж зардал тайланд тусгасан | 1 | 990.0 | 1 | 990.0 | - | - | - | - | - | -- | - | |
| Автотээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээг байгууллагын нэр дээр эзэмшигчээр бүртгэлгүй | 1 | 0,0 | -- | | 1 | 0,0 | - | - | - | -- | - | - |
| Газрын кадастрын нэгдсэн системд Засаг даргын Тамгын газар эзэмшигчээр бүртгэлтэй 1827м$^{2}$ нам олон нийтийн байгууллагын зориулалтай 3 газар байна. | 1 | 3,654.0 | - | - | 1 | 3,654.0 | - | - | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8 тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй. | 1 | 0,0 | - | - | - | - | 1 | 0,0 | - | - | - | - |
| Нягтлан бодогч солигдох үед тооллого хийгээгүй | 1 | 3,781,202.5 | | | 1 | 3,781,202.5 | | | | | | |
| Хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаа явуулдаг Даянхилэв ХХК-аас 3 нэр төрлийн 6.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 836.0 мянган төгрөгөөр самбар худалдан авсан байна | 1 | 7,336.0 | | | 1 | 7,336.0 | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын зардлын дансанд тусгагдсан 4 ажлын урьдчилгаа төлбөрийн 54.0 сая төгрөгийн гүйлгээг НББ-ийн стандартын дагуу давхар бичилтийг хийж урьдчилж | 1 | 54,000.0 | | | 1 | 54,000.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| гарсан зардлаар бүртгээгүй, шууд зардалд тусгасан. | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **3,847,182.5** | **1** | **990.0** | **2** | **3,846,192.5** | **1** | **0** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Shilendans.gov.mn цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 196.9 сая төгрөгийн 15 гүйлгээг, зарлагын 10.0 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 205,870.6 | - | - | 1 | 205,870.6 | - | - |
| Дүн | 1 | 205,870.6 | - | - | 1 | 205,870.6 | - | - |